

КОПЕНГАГЕН СУРГУУЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОНОЛ¹

Э.Өлзийлхам²

Оршил

Дани улсын Копенгаген хотод байрладаг Зөрчилдөөн болон энхтайваны судлагааны хүрээлэнгээс (Copenhagen Conflict and Peace Research Institute) 1990-ээд оны эхээр олон улсын харилцааны салбарт хүлээн зөвшөөрөгдөж³ өргөн хүрээтэйгээр хэрэглэгдэх болсон⁴ Копенгаген сургуулийн аюулгүй байдлын онолыг (КСАБО) боловсруулжээ. Тус онолын гол төлөөлөгчид нь Барри Бузан болон Оле Вэбэр нарын эрдэмтэд юм. Жеф Хюсманс КСАБО-ын талаарх дөрвөн гол сурах бичгийг нэрлэсэн билээ.⁵ Эдгээр ном, сурах бичгүүдийн эхний гурвын нэр буюу *Европын аюулгүй байдал – Зэвсгийн бус асуудлаар судалгаа хийхэд учрах бэрхшээлүүд (European Security - Problems of Research on Non-military Aspects)*, *Европын олон ургальч үзлийн талбар: Зүүн-Барууны сөргөлдөөнт үзлээс давсан үзэл санаа (European Polyphony: Perspectives Beyond East-West Confrontation)*, *Европын аюулгүй байдлын дэглэмийг өөрчлөх нь. Хүйтэн дайны дараах дүр зураг (The European Security Order Recast. Scenarios for the Post-Cold War Era)* зэргээс харахад тус Хүрээлэнгийн эдгээр судалгаа шинжилгээний ажлын гол зорилго нь Европын бүс нутгийн хүрээнд аюулгүй байдлын асуудлыг судлах, боловсруулахад оршиж байсан гэдэг нь харагдаж байна. Харин тус Хүрээлэнгийн дөрөв дэх бүтээл болох *Аюулгүй байдал: судалгааны шинэлэг онол (Security: A New Framework*

¹ Энэхүү өгүүллийг Казакстан улсын Алма-Ата хотод 2008 оны 5-р сарын 18-26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Судалгааны арга зүй боловсруулах” семинарт гадаадын эрдэмтдээр хэлэлцүүлсэн болно. Зохиогчийн судалгааны ажилд санал зөвлөгөө өгч, шүүмжилсэн Д-р Рик Фон, Д-р Галина Битьюкова, Д-р Салли Каммингс нарт талархал илэхийлье. Мөн түүнчлэн тус семинарт оролцоход санхүүжилт олгосон Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Төв Азийн Судалгаа, Сургалтын Хөтөлбөрт талархалаа илэрхийлье.

² МУИС, ОУХС-ийн багш, доктор /Sc.D/, профессор. ЗХУ-д 1984-1990 онуудад Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдаар ажиллаж байсан. Хүндэт дипломатч.

³ Майкл Виллиамс болон Ёхан Эриксон нар хоёулаа КСАБО-ыг аюулгүй байдлын судлалд “хамгийн дэвшилтэт” болон “нилээдгүй нөлөө бүхий” онол болж чадсан хэмээн санал нэгдэж байна (Michael C. Williams, “Words, Images, Enemies: Securitization and International Politics”, *International Studies Quarterly* 47 (2003): 511-р тал болон Johan Eriksson, Book Review: ‘Security: A New Framework for Analysis’, *Journal of Contingencies and Crisis Management* 9, no. 1 (March 2001): 61-р тал зэргийг харна уу. Тус онолын талаарх хамгийн сүүлийн үеийн өгүүлүүдийг *European Journal of International Relations* сэтгүүл дээр Тэрри Балзак, Холгер Стритзел болон Матт Макдоналд зэрэг эрдэмтдийн 2005, 2007, 2008 онуудад хэвлүүлсэн болно.

⁴ КСАБО нь Пол Ро, Жеф Хюсманс, Грам Херд болон Ёхан Лофгрен зэрэг эрдэмтдийн судалгааны ажилд нөлөөлсөн юм. (Paul Roe, “Misperception and Ethnic Conflict: Transylvania’s Societal Security Dilemma”, *Review of International Studies*, no 28 (2002), Jef Huysmans, ‘Migrants as a Security Problem: Dangers of ‘Securitizing’ Societal Issues’ in Robert Miles and Dietrich Thranhardt *Migration and European Integration* (London: Pinter Publishers, 1995) болон Herd and Lofgren, “‘Societal Security’, the Baltic States and EU Integration”, *Cooperation and Conflict* 36, no. 3 (2001) зэргийг харна уу).

⁵ Jef Huysmans, “Revisiting Copenhagen: Or, On the Creative Development of a Security Studies Agenda in Europe”, *Review Article: European Journal of International Relations* 4, no. 4 (1998): 479-р тал.

for Analysis) хэмээх ном нь Европоос бусад бүс нутагт “аюулгүй байдлын цэгцтэй онол”⁶ боловсруулах томоохон зорилго агуулсан бүтээл турвисныг илтгэнэ. Тийм ч учраас энэхүү бүтээл нь Копенгаген сургуулийн аюулгүй байдлын онолын гол дорвитой бүтээл болж чадсан юм.

Иймээс тус өгүүлэл нь КСАБО-ын үндсэн ойлголт, ухагдахууныг тайлбарлахын зэрэгцээ дэвшилтэт болон дутагдалтай талууд, онолыг тойрсон судлаачдын маргаан зэргийг танилцуулах болно. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд өгүүллийг дөрвөн хэсэгт хуваасан юм. Нэгдүгээрт: КСАБО-ын тулгуур ойлголт болох “securitization” буюу “аюулгүй байдлын асуудалд дэвшүүлэх”, мөн үүний эсрэг ойлголт болох “desecuritization” буюу “аюулгүй байдлын асуудлаас гаргах” гэсэн ухагдахууныг тайлбарлана. Хоёрдугаарт: КСАБО-ын “аюулгүй байдлын асуудалд дэвшүүлэх” гэсэн ухагдахууны цаадах “найз болон дайсан” хэмээх зааглалыг тайлбарлана. Гуравдугаарт: КСАБО-ын гүйцэд боловсруулаагүй орхисон “desecuritization” буюу “аюулгүй байдлын асуудлаас гаргах” стратегийг боловсруулах үүднээс хүний аюулгүй байдлын ойлголтыг дэвшүүлэх болно. Эцэст нь өгүүлэлд гарсан гол санаануудыг нэгтгэн дүгнэж цаашид хийх судалгааны чиглэлийг тодорхойлно.

Копенгаген сургуулийн аюулгүй байдлын онол (КСАБО): ‘Аюулгүй байдлын асуудалд дэвшүүлэх болон аюулгүй байдлын асуудлаас гаргах’

Копенгагены зөрчилдөөн болон энхтайваны судалгааны хүрээлэнгээс боловсруулсан Копенгаген сургуулийн аюулгүй байдлын онол (КСАБО) нь хүйтэн дайны дараах үеийн аюулгүй байдлын салбарт гарсан шинэчлэл, маргаантай холбогдуулан үүссэн тул энэхүү онолын үндэслэлийг тус орчинтой салшгүй холбон авч үзэх ёстой.

Хүйтэн дайн дуусахад аюулгүй байдлын судлаачид аюулгүй байдлын хүрээг тэлж тус салбарт цэрэг, зэвсгийн бус асуудлыг өргөнөөр хамруулах асуудлыг идэвхтэй дэвшүүлж эхэлсэн. Энэ нь Зүүн болон Барууны хоорондох сөргөлдөөн саарч ирснээр уламжлалт реалистуудын аюулгүй байдлыг зөвхөн цэргийн хүч болон улс төвтэйгээр салшгүй холбон авч үзэх үзэл ач холбогдлоо алдсанаар ийнхүү үзэл идэвхжиж ирсэн⁷. Иймээс шинийг эрэлхийлэгч судлаачид аюулгүй байдлын асуудлыг зөвхөн цэрэг, зэвсгийн төвлөрлөөс гарган хүний оршихуйд заналхийлж болох бусад асуудлууд болох эдийн засаг, байгаль орчин, соёл иргэншил⁸ зэрэг асуудлуудад чиглүүлэхийг зорьсон билээ. Тухайн үед давамгайлж байсан урсгалын гажилт, сөрөг үр дагаврыг хүлээн зөвшөөрсний илэрхийлэл болж олон улсын харилцааны нэр хүндтэй сэтгүүлийн нэг болох *International Studies Quarterly* нь өөрийнхөө 1990 оны дугаарыг бүхэлд нь тухайн үед хязгаарлагдмал байр суурь эзлэж байсан “тэрс үзэлтний дуу хоолой”-д зориулсан юм. Энэхүү үйлдэл нь тухайн цаг үед шүүмжлэлтэй байр суурийг илэрхийлэх болсон судлаачид хэрхэн уламжлалт реалист урсгалыг сөрж гарч ирэх болсныг илтгэж байна.

Ийнхүү судалгааны шинэ орон зай бий болсноор цэрэг, зэвсгийн бус аюул заналууд болох байгаль орчны доройтол⁹, дотоодын нөөцийн хомсдол¹⁰ зэрэг аюулгүй байдлын салбарыг өргөжүүлсэн судалгааны ажлууд нилээдгүй гарч ирсэн. Аюулгүй байдлын хүрээг ийнхүү тэлэх

⁶ Barry Buzan, Ole Waever and Jaap de Wilde, Chapter 1: ‘Introduction’ in *Security: A New Framework for Analysis* (London: Lynne Rienner Publishers, 1998): 1-р тал.

⁷ Barry Buzan, Ole Waever, and Jaap de Wilde, *Security: A New Framework for Analysis*. Boulder: Lynne Rienner, 1998: 3, and Barry Buzan, “Rethinking after the Cold War”, *Cooperation and Conflict* 32, no. 1 (1997): 6-9-р тал.

⁸ Helga Haftendorn, “The Security Puzzle: Theory-Building and Discipline-Building in International Security”. *International Studies Quarterly* 35 (1991): 11 болон 16-р тал.

⁹ Дэлхийн Нөөцийн хүрээлэнгийн дэд ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэж байсан Жессика Тучман Матьюс аюулгүй байдлын байгаль орчны асуудлыг ихээхэн дэлгэрүүлж бичиж байсан. Тэрээр усны хомсдол, ойгүйжилт, бэлчээр талхалт, озоны давхаргын цооролтын аюул зэргийн талаар бичих болсон. (Jessica Tuchman Mathews, “Redefining Security”, *Foreign Affairs* 68, no. 2 (1989): 166-171-р тал).

¹⁰ Энэ нь эдийн засгийн аюулын төрөл юм. Ричард Уллман эдийн засгийн аюулгүй байдлын асуудлын хүрээнд Америкийн газрын тосны хэт их нөлөөнд автсан байдлыг сануулж бичиж эхэлсэн. (Richard Ullman, “Redefining Security”, *International Security* 8, no.1 (1983): 132-р тал).

болсон үндэслэлийг эдгээр судлаачид аюулгүй байдлыг зөвхөн цэрэг, зэвсгийн хүчин зүйлээр тодорхойлж байсан уламжлалт реалист аюулгүй байдлын онолын хязгаарлагдмал шинжийг харуулсан¹¹. Ричард Уллманы ажигласнаар “үндэсний аюулгүй байдлыг зөвхөн (эсвэл ихэвчлэн) цэрэг, зэвсгийн томъёоллоор тодорхойлох нь бодит байдлын талаар өрөөсгөл дүр зургийг бий болгож байна” гэжээ¹². Шинээр давамгайлах болсон өөрчлөлтийн нөлөөнд эдгээр судлаачид реалист аюулгүй байдлын онолын хязгаарлагдмал байдал болон аюулгүй байдлын цэрэг, зэвсгээс ангид талыг харуулж чадсан.

Гэсэн хэдий ч аюулгүй байдлын цэргийн хүчний хүчин зүйлийн эсрэг сөрж зогссон “аюулгүй байдлын онолыг өргөжүүлэгчдийн” эсрэг уламжлалт реалистууд мөн хариу шүүмжлэл дэвшүүлсэн. Тэд аюулгүй байдлыг өргөжүүлэхийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрсөн хэдий ч “аюулгүй байдалд учирч болох аюулт үзэгдлүүдэд агаарын бохирдол, өвчин эмгэг, хүүхдийн хүчирхийлэл, эсвэл эдийн засгийн уналт зэрэг бүх асуудлыг оруулж, хэт их өргөжүүлэхээс”¹³ сэрэмжлүүлсэн. Тэд аюулгүй байдлын салбарыг энэ чиглэлээр цаашид хөгжүүлбэл аюулгүй байдлын онолын “уялдаа холбоог” гажуудуулж, эдгээр асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх боломжийг нь алдагдуулна хэмээн үзэж байна. Нөгөөтэйгүүр Копенгаген сургуулийн аюулгүй байдлын онол (КСАБО) нь аюулгүй байдлын логикийг хадгалснаар аюулгүй байдлын цогц онолыг боловсруулж чадсан. КСАБО-ыг дэвшүүлэгчид аюулгүй байдлыг онцгой байдлаар хэлэгдэж, хэрэгждэг учир бусад чиглэлд өргөжүүлэхийн тулд аюулгүй байдлын логик утгыг нарийвчлан судлах ёстой гэж үзсэн.

КСАБО-ын суурь ойлголт нь олон улсын аюулгүй байдал нь “уламжлалт хүчний улс төрийн” хүрээнд онцгой утга агуулдаг¹⁴ гэсэн үзлээс үүсэлтэй. Аюулгүй байдлыг хэрэгжүүлэх практик нь тухайн асуудлыг улс төрийн онцгой, нэн яаралтай байдалд¹⁵ хандуулснаар тухайн нэгжийн систем амьд явах зорилгод чиглэгддэг¹⁶. Ямар нэгэн асуудлыг аюулгүй байдлын асуудалд дэвшүүлснээр тухайн үүргийг хариуцсан албан тушаалтан нь ийнхүү нэрлэгдсэн аюулыг устгахын тулд өндөржүүлсэн онцгой арга барил замаар шийдвэрлүүлэх үүргийг хүлээдэг¹⁷. Амьд явах асуудал нь бусад бүх асуудлын дээр тавигдаж “хэрэв бид энэхүү бэрхшээлийг шийдвэрлэхгүй бол бусад бүх зүйл утга учраа алдана (учир нь бид байхгүй эсвэл өөрсдийн аргаар эдгээр асуудлыг шийдвэрлэх эрх чөлөөгүй болно)”¹⁸ хэмээн үздэг байна. Тухайн асуудлыг аюулгүй байдалд дэвшүүлэх нь аюулыг устгахын тулд өндөржүүлсэн онцгой арга хэмжээ буюу хүч хэрэглэх эсвэл “тухайн аюулт үзэгдлийг газар авахаас өмнө зогсоох бүхий л шаардагдах арга хэмжээ авах”-ыг шаарддаг байна¹⁹. Ийм ч учраас “аюулгүй байдлын логик” буюу “аюулгүй байдалд асуудал дэвшүүлэх үйлдэл” нь түүнийг хэрэгжүүлэх практикаас харагддаг бөгөөд аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд хэвийн бус онцгой байдлын журмаар шийдвэрлэдэг байна²⁰.

КСАБО-оор аюулгүй байдлын асуудалд дэвшүүлэх үйл явцыг аюулгүй байдлын асуудалд дэвшүүлж буй албан тушаалтны зарласнаар хэрэгждэг хэлэхүйн үйлдэл хэмээн тодорхойлдог. Аюулыг онцгой арга хэмжээ авч шийдвэрлэхийг шаарддаг. Гэсэн хэдий ч ийнхүү онцгой байдал зарлах нь аюулгүй байдлын асуудалд дэвшүүлж буй үйлдлийн зөвхөн нэг тал нь болдог²¹.

¹¹ Joseph Nye and Sean M. Lynn-Jones, “International Security Studies”, International Security 12, no.4 (1988): 5-27-р тал.

¹² Ullman, 129-р тал.

¹³ Stephen M. Walt, “The Renaissance of Security Studies”, International Studies Quarterly 35 (1991): 213-р тал.

¹⁴ Waever et al., 21-р тал.

¹⁵ Ole Waever, ‘Securitization and Desecuritization’ in Ronnie D. Lipschutz (ed.), On Security, New York: Columbia University Press, 1995: 226-р тал.

¹⁶ Ole Waever, ‘What Is Security? - The Securityness of Security’ in Birthe Hansen (ed.), European Security 2000 [Европын аюулгүй байдал 2000], Copenhagen: Political Studies Press, 1995: 53-р тал.

¹⁷ Waever, ‘Securitization and Desecuritization’ 227-р тал.

¹⁸ Waever et al., 24-р тал.

¹⁹ Мөн тэнд. 21-р тал.

²⁰ Waever, ‘Securitization and Desecuritization’ 226-р тал.

²¹ Waever et al., 25-р тал.

Аюулгүй байдлын асуудалд дэвшүүлэхийг олон нийт ийм шаардлага байна хэмээн хүлээн зөвшөөрснөөр бүрэн хангагдана. Иймээс олон нийт аюулгүй байдлын асуудалд дэвшүүлэх үйлдлийн салшгүй нэг хэсэг болдог. Учир нь аюулгүй байдлын үйлдлийг ихэвчлэн тодорхой бүлэг хүмүүсийн буюу систем доторх бусад бүлэг хүмүүсээс амьд явах эрхийг хэрэгжүүлэх эрхтэй бүлгийн нэрийн өмнөөс хэрэгжүүлдэг²² бөгөөд энэ нь ихэвчлэн улс орон эсвэл нийгэм байдаг. Аюулгүй байдал нь аюулаас ангид байхад чиглэгдсэн хүсэл зориг бөгөөд энэ нь тухайн аюулаас улс орон эсвэл нийгэмд өөрсдийнхөө оршихуйн илэрхийлэл (identity), бүрэн бүтэн байдал болон оршин тогтнолоо бие даан авч явах бололцоог олгодог²³. Иймээс аюулгүй байдлын асуудалд дэвшүүлэх үйлдлийг хэрэгжүүлэхийн тулд аюул нь “бодит” объектив байдлаараа²⁴ байгаа эсэх нь хамаагүй, харин тухайн аюулыг байна хэмээн нийтээрээ хүлээн зөвшөөрч, ийн хариу үйлдэл хийж байгаа нь л ач холбогдолтой юм²⁵. Үүнээс харахад аюулгүй байдлын асуудалд дэвшүүлэх үйл явцыг олж тогтоохын тулд судлаачид тухайн заналхийллийг аюул гэдгээр нь нийтээрээ хүлээн авахад юу нөлөөлж байна вэ гэдгийг олж тогтоох нь чухал байдаг. Энэхүү үйл явцыг тогтоохын тулд КСАБО нь констрактивист онолыг хэрэглэдэг.

Констрактивист онолын дагуу КСАБО нь “аюулгүй байдлын асуудалд дэвшүүлэх үйл явц нь субъект хоорондын үйл явц”²⁶ гэж үздэг бөгөөд ингэснээр аюулыг тодорхойлох нь тухайн харилцаанд оролцогчдоос хамааралтай²⁷. Аюулгүй байдлын асуудалд дэвшүүлэгч эрх бүхий албан тушаалтан болон олон нийтийн хооронд тухайн асуудал нь онцгой арга хэмжээг шаардсан, тэдний оршин тогтнолд заналхийлсэн аюул мөн эсэх дээр нийтлэг ойлголттой байх ёстой. Энэхүү нийтлэг ойлголт нь эдгээр оролцогчид өөрсдийнхөө оршихуйн илэрхийллийг юу гэж тодорхойлж байгаагаар илрэх бөгөөд энэ нь оршин тогтнолд заналхийлсэн аюул хэмээн тодорхойлох боломжийг бүрдүүлдэг.

Ийм ч учраас аюулгүй байдлыг өргөжүүлэхийг санал болгогч эрдэмтэдтэй харьцуулахад КСАБО нь аюулгүй байдлын үндсэн утгыг алдагдуулалгүйгээр аюулгүй байдлын асуудалд дэвшүүлэх үйлдэл бүрийг тодорхойлох боломжийг олгодог. Аюулгүй байдлын логик утгыг хадгалснаар аюулгүй байдлын асуудалд дэвшүүлэх үйлдэл бүрийг тодорхойлж, хүний оршин тогтнолд заналхийлж буй бүхий л асуудлыг аюулгүй байдал гэж авч үзэх шаардлагагүйгээр аюулгүй байдлыг өргөжүүлэх боломжтой болсон. Тус онолыг боловсруулагчдын үзэж байгаагаар аюулгүй байдал нь хүний амьдралын бүхий л салбарын юу нь сайн юм бэ гэдгийг тодорхойлогч үнэлгээний хэмжүүр бус²⁸ харин энэ нь хүний оршин тогтнолд заналхийлсэн аюулын эсрэг өндөржүүлсэн арга хэмжээ авахыг уриалсан онцлог хэллэг юм. Ингэснээр КСАБО нь аюулгүй байдлын асуудлыг цэргийн хүчнээс гадна бусад дөрвөн салбар буюу эдийн засаг, улс төр, нийгэм болон байгаль орчин зэрэгт амжилттайгаар өргөжүүлэх боломжтой болгосон.

Нөгөөтэйгүүр КСАБО-ын хүрээнд аюулгүй байдлын асуудлыг хэт олноор гаргаж ирэхээс сэрэмжлүүлсэн. Учир нь ийм үйлдэл хийх нь ердийн арга замаар шийдвэрлэх боломжоо алдаж, хэвийн бус онцгой аргаар аливаа асуудлыг ердийн улс төрийн тоглоомын дүрмийг эвдэхэд хүргэдэг гэж үзсэн²⁹. Иймээс аюулгүй байдлын асуудлыг хэт олноор дэвшүүлэх нь аюулгүй байдлыг бус аюултай байдлыг бий болгодог байна. Хюсмансын тайлбарласнаар аюулгүй

²² Мөн тэнд. 36-р тал.

²³ Barry Buzan, “New Patterns of Global Security in the Twenty-first Century”. International Affairs 67, no. 1 (1991): 432-р тал.

²⁴ Арнолд Волферс объектив болон субъектив аюулгүй байдлын хоорондох ялгааг гаргахдаа: “объектив аюулгүй байдал нь үнэт зүйлийн эсрэг аюул байхгүйг илэрхийлдэг бол субъектив аюулгүй байдал нь эдгээр үнэт зүйлсийн эсрэг заналхийлнэ гэсэн айдас байхгүйгээр хэмжигддэг” хэмээн үзсэн. (Arnold Wolfers, *Discord and Collaboration*. Baltimore: Johns Hopkins University Press, 1962: 150-р тал).

²⁵ Waever et al., 24, 26-р тал.

²⁶ Мөн тэнд. 31-р тал.

²⁷ Мөн тэнд. 30-31-р тал.

²⁸ Waever, ‘Securitization and Desecuritization’, 222-р тал.

²⁹ Waever et al., 29; Ole Waever, ‘What Is Security? - The Securityness of Security’ in Birthe Hansen (ed.) *European Security* 2000. Copenhagen: Political Studies Press, 1995: 54-58-р тал.

байдлын үйл ажиллагаанд уриалан дуудах нь нийгмийн харилцааг “бид” бол “тэдний” эсрэг хэмээх байдлаар зохион байгуулалтанд оруулдаг байна³⁰. Иймээс дараагийн бүлэгт аюулгүй байдлын үйл ажиллагааны сөрөг үр дагаврыг авч үзье.

Аюулгүй байдлын зохион байгуулалт: ‘найзууд болон дайснууд’

Хюсманс аюулгүй байдал нь нийгмийн харилцааг найзууд болон дайснуудын хоорондох байдлаар зохион байгуулах онцгой үүрэгтэй хэмээн тэмдэглэсэн³¹. Копенгаген сургуулийн аюулгүй байдлын онолын (КСАБО) баримталдаг олон улсын аюулгүй байдлын “логик” утга нь Хоббсын “бүгдийн эсрэг бүх нийтийн дайны айдас” гэсэн ойлголттой салшгүй холбоотойгоор үүссэн. Нэгэнт л аюулгүй байдлын асуудалд дэвшүүлсэн бол дайснуудад “зэрлэгээр амиа хорлуулах”³² гэсэн айдас нь энэхүү үйлдэлд давамгайлж байдаг. Хюсмансын үзэж байгаагаар энэхүү аюулгүй байдлын үйлдэл нь гурван зүйлийг агуулдаг: “аюул, аюулд өртөж буй объект болон энэхүү объектын оршихуйн илэрхийллийн халдашгүй байдлыг хадгалах” зэрэг ордог³³. Аюулгүй байдалд уриалан дуудах үйлдэл нь аюулаас хамгаалагдах шаардлагатай оршихуйн илэрхийллийг бүтээхийг шаарддаг байна. Энэхүү бүтээгдэх үйл явцыг КСАБО-ын ашигладаг контрактивистын онолоос олж харж болно.

Контрактивистын онолоор тухайн харилцаанд оролцогчийн оршихуйн илэрхийллийн үүсэх болсон шалтгаан, үйл явцыг ойлгох нь тэдний үйл хөдлөлийг ойлгоход дөхөмтэй болгодог. Судлаач Тэд Хопфын үзэж байгаагаар оролцогчийн оршихуйн илэрхийлэл нь тодорхой сонголт, хүсэл зоригийн нийлбэрийг бий болгож, тэдний дараах үйлдлийг таамаглахад дөхөмтэй болгодог³⁴. Иймээс тухайн оролцогчийн оршихуйн илэрхийлэл нь реалистуудын үздэгээр угийн байдаг бус харин тодорхой түүхэн, соёлын, улс төрийн болон нийгмийн орчинд оролцогчдын хооронд бүрэлддэг бүтээгдэхүүн болдог³⁵. Нэгэнт бүрэлдэн бий болсноор энэхүү аюулгүй байдлын үйлдэл нь “онцгой ач холбогдолтой байдаг: энэ нь тантай найз эсвэл дайсны байр сууриас харилцах эсэхийг тодорхойлдог”³⁶. Ийм ч учраас тухайн оршихуйн илэрхийллийг бүрдүүлэх үйл явц нь тухайн оролцогчийн цаашдын үйл хөдлөлийг ойлгох, таамаглах боломжийг олгодог.

Контрактивистууд оролцогчийн оршихуйн илэрхийллийн бүтээгдэх үйл явцыг олж тогтоохын тулд энэхүү үйл явцад нөлөөлсөн оролцогчдын нийтлэг ойлголтыг ойлгохыг чухалчилдаг. Энэхүү нийтлэг ойлголтыг “субъект хоорондын харилцаанаас үүсэлтэй”³⁷ гэж үздэг. Субъект хоорондын харилцаанд оролцогчид тэдний үйл хөдлөлийг удирдан зохицуулж байдаг дүрэм журам, хэм хэмжээнд захирагдаж, нийтлэг ойлголттой болж байдаг³⁸. Ийнхүү нийтлэг дүрэм журмыг дагаснаар тэд юуг “хийж болох” болон юуг “хийж болохгүй” талаар мэдээлэл авдаг³⁹.

Контрактивистуудын үзэж байгаагаар “хэдийгээр эдгээр мэдээллийг харилцаанд оролцогчид субъект хоорондын харилцаанд оролцсоноор олж авч, бүрдүүлдэг хэдий ч”⁴⁰ энэхүү нийтлэг ойлголт, мэдээлэл нь тухайн нийгмийн харилцаанд оролцогчдын дараагаар

³⁰ Huysmans, ‘Migrants as a Security Problem: Dangers of ‘Securitizing’ Societal Issues’.

³¹ Huysmans, “Revisiting Copenhagen: Or, On the Creative Development of a Security Studies Agenda in Europe”, 479-505-р тал.

³² Jef Huysmans, “The Question of the Limit: Desecuritization and the Aesthetics of Horror in Political Realism”, Millennium 27, no. 3: 571-р тал.

³³ Huysmans, ‘Migrants as a Security Problem: Dangers of ‘Securitizing’ Societal Issues’, 54-р тал.

³⁴ Ted Hopf, “The Promise of Constructivism in International Theory”, International Security 23, no. 1.

³⁵ Мөн тэнд. 174-р тал.

³⁶ Marysia Zalewski and Cynthia Enloe, “Questions about Identity in International Relations” in Ken Booth and Steve Smith (eds.), International Relations Theory Today. Cambridge: Polity Press, 1995: 281-283-р тал.

³⁷ Emanuel Adler, “Seizing the Middle Ground: Constructivism in World Politics”, European Journal of International Relations 3, no. 3 (1997): 327-р тал.

³⁸ Badredine Arfi, “Ethnic Fear: The Social Construction of Insecurity”, Security Studies 8, no. 1 (1998): 155-р тал.

³⁹ Мөн тэнд. 157, 169-р тал; Adler, 322-р тал.

⁴⁰ Alexander Wendt, “Anarchy is What States Make of it: Social Construction of Power Politics”, International Organization 46, no. 2 (1992): 399-р тал.

оршин тогтнож, тэдгээрийн нийгмийн бодит байдлыг бүрдүүлж байдаг онцлогтой⁴¹. Ингэснээр субъект хоорондын ойлголтууд нь Ричард Ашлигийн тодорхойлсноор “болж өнгөрсөн үйл явдал дээр тодорхой нэгэн тайлбарыг үүсгэн, бусад сөрөг тайлбаруудыг үгүйсгэж, үйл ажиллагааны нөхцлийг бүрдүүлж, нийтийн түүхийг бүтээж байдаг” хүчирхэг ухагдахуун байдаг гэжээ⁴². Мөн түүнчлэн тодорхой нэгэн оршихуйн илэрхийллийн удаан оршин тогтнох болсон шалтгааныг тайлбарладаг, учир нь нэгэнт бүтээгдсэн бол энэ нь тогтсон субъект хоорондын ойлголтоор хязгаарлагдаж⁴³, тухайн оролцогчийн үйл хөдлөлийг урьдчилан таамаглах үндэс болдог⁴⁴ байна.

Констрактивист онолын хүрээнд харилцаанд оролцогч нь өөрийн оршихуйн илэрхийллийг тодорхой нэг аюулын эсрэг бий болгодог. Хюсмансын үзэж байгаагаар энэ нь “эсрэг тэсрэг хоёр зүйлийн хоорондох харилцааг” бүрдүүлдэг⁴⁵. Ийнхүү айдаст автсан оролцогч энэхүү аюулт үйл явдал бий болохоос зайлсхийх бүхий л арга хэрэгслийг хэрэглэдэг. Энэ явдал удааших тусам айдас улам бүр нэмэгдэж, зөрчилдөөн бий болоход хүргэдэг⁴⁶. Иймээс нийгмийн асуудлыг аюулгүй байдлын асуудалд дэвшүүлэх нь аюулгүй байдлыг нэмэгдүүлэх бус багасгадаг учир дараагийн хэсэгт хүний аюулгүй байдлын ойлголтыг хэрхэн аюулгүй байдлын асуудлаас гаргах хэрэгсэл болгож болох талаар өгүүлэе.

Хүний аюулгүй байдал: ‘Нийгмийн аюулгүй байдлын асуудлыг аюулгүй байдлын асуудлаас гаргах хэрэгсэл болгох нь

Дээрхээс харахад Копенгаген сургуулийн аюулгүй байдлын онол (КСАБО) нь хэт олон аюулгүй байдлын асуудал дэвшүүлэх нь аюултай бөгөөд энэ нь хэвийн улс төрийн үйл ажиллагааг гажуудуулж, тухайн асуудлыг онцгой арга хэмжээгээр зохицуулахыг шаарддаг байна. Тиймээс тус онолоор ийнхүү аюулгүй байдлыг даамжруулахаас сэрэмжлүүлдэг, учир нь төрийн тэргүүн нар асуудлыг хэвийн улс төрийн хүрээнээс гаргаж шийдвэрлэхдээ “тухайн аюулыг дотоодын хэрэгт нийцүүлэн ашиглаж” сөрөг хүчнийг дарахад ашиглах хэрэгсэл болгож болно гэж үздэг.⁴⁷ Тиймээс КСАБО-ыг баримтлагчид аюулгүй байдлын асуудлаас гаргах, өөрөөр хэлбэл хэвийн улс төрийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх нь удаан хугацаанд эерэг бөгөөд энхтайван, аюулгүй байдлыг бүрдүүлэх нөхцөл болдог гэж үздэг.⁴⁸

Гэсэн хэдий ч КСАБО-ыг боловсруулагчид аюулгүй байдлын асуудлаас гаргах арга замыг тодорхойлохыг дургүйцдэг бөгөөд энэхүү онолоор зөвхөн тухайн асуудал хэрхэн аюулгүй байдлын асуудалд дэвшүүлэгддэг талаар л харуулах боломжтой гэж үзсэн⁴⁹. Иймээс энэхүү үзэл санаа нь тус онолыг дутмаг болгож байгаа тул тус судалгаа нь сүүлийн үед нэр хүндээ олох болсон альтернатив (шүүмжлэлтэй) аюулгүй байдлын онолыг (ААБО) ашиглаж, өөрчлөлтийг хэрхэн хийх талаар санал болгоё.

ААБО нь өнөөгийн аюулгүй байдал нь “буруугаар” улс орныг аюулгүй байдлын объект болгон өргөмжилсөн⁵⁰ гэж үздэг. Кен Бувын үзэж байгаагаар жинхэнэ аюулгүй байдал нь “хүмүүс, хувь хүн болон бүлгүүдийг өөрсдийнх нь чөлөөтэй сонгох үйлдэлд нь саад болж байгаа нийгэм, эдийн засаг, улс төр болон бусад хязгаарлалтуудаас нь ангижруулснаар” бодит

⁴¹ Adler, 327-р тал.

⁴² Richard K. Ashley, “Untying the Sovereign State: A Double Reading of the Anarchy Problematique”, *Millennium: Journal of International Studies* 17, no. 2 (1988): 243-р тал.

⁴³ Arfi, 169-р тал; Wendt, 402-р тал.

⁴⁴ David Campbell, *Writing Security: United States Foreign Policy and the Politics of Identity*. Manchester: Manchester University Press, 1992: 158-р тал.

⁴⁵ Huysmans, ‘Migrants as a Security Problem: Dangers of ‘Securitizing’ Societal Issues’, 57-р тал.

⁴⁶ Мөн тэнд. 65-р тал.

⁴⁷ Weaver, *Security: A New Framework for Analysis*, Chapter 2: ‘Security Analysis: Conceptual Apparatus’, 29-р тал.

⁴⁸ Мөн тэнд.

⁴⁹ Мөн тэнд.

⁵⁰ Ken Booth, “Security and Emancipation”, *Review of International Studies*, no 17 (1991): 319-р тал.

биеллээ олно гэж үзсэн⁵¹. Ингэснээр улс орнууд нь аюулгүй байдлыг бүрдүүлэх зорилт бус арга хэрэгсэл нь болж, аюулгүй байдлын эцсийн зорилт нь хүний аюулгүй байдлыг бий болгох гэж үздэг⁵². Ийнхүү хүний аюулгүй байдлын ойлголт нь хүний аюулгүй байдлыг эцсийн объект болгодог.

Ихэнх судлаачид Нэгдсэн үндэстний байгууллагын 1994 онд гаргасан *Хүний хөгжлийн тайлан*г хүний аюулгүй байдлын ойлголтын анхны эх сурвалж гэж үздэг⁵³. Тус тайланд хүний аюулгүй байдлын ойлголтыг тодорхойлохдоо аюулгүй байдлыг хүн рүү чиглэсэн байх ёстой, тиймээс энэ нь хүмүүс нийгэмд хэрхэн аж төрж, оршин тогтнож байна, тэд өөрсдийнхөө сонголтыг хэрхэн чөлөөтэй хэрэгжүүлж чадаж байна, мөн зах зээл болон нийгмийн боломжийг хэрхэн олж авах боломжтой байхаас гадна зөрчилдөөн эсвэл энхтайвны дунд оршин тогтнож байгаа эсэхийг авч үзэх ёстой гэж үзсэн⁵⁴. Энэхүү тайланд хүний аюулгүй байдал гэдэг нь нэгдүгээрт, “байнгын аюулууд болох өлсгөлөн, өвчин болон улс төрийн хавчлага, хоёрдугаарт, өдөр тутмын амьдралд учирч болох гэнэтийн аюулаас хамгаалагдах” зэрэг болно гэжээ⁵⁵. Гэсэн хэдий ч энэхүү ойлголтыг нийгмийн асуудлыг аюулгүй байдлын асуудлаас гаргах хэрэгсэл болгохын тулд хоёр бэрхшээлийг шийдвэрлэх ёстой.

Нэгдүгээрт ихэнх судлаачид одоогийн байдлаар хүний аюулгүй байдлын ойлголтыг судалгаа, шинжилгээнд хэрэгцээтэй хэрэгсэл болгоход хэт их өргөн байна хэмээн үздэг⁵⁶. Роланд Парисын үзэж байгаагаар “хүний амь биеийн аюулгүй байдлаас сэтгэл санааны эрүүл байдлыг багтаасан хүний аюулгүй байдлын ойлголт” нь судлаачид болон практик ажилтнуудад үйл ажиллагааны чиглэл өгөхдөө тааруу байдаг⁵⁷. Энэ нь уламжлалт реалистуудын аюулгүй байдлын асуудлыг хэт их өргөжүүлснээр, аюулгүй байдлын ойлголтыг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй болгодог хэмээн сэрэмжлүүлж байсантай санаа нэг юм. Тухайлбал, Хью Даер болон Даниел Дудни нар аюулгүй байдлын ойлголтыг байгаль орчны аюулгүй байдал руу өргөжүүлэхийн эсрэг байр суурьтай байдаг⁵⁸. Тэд үзэхдээ аюулгүй байдлын ойлголт нь “зохион байгуулалттай хүчирхийллийн”⁵⁹ хүрээнд бүрэлддэг бөгөөд “тэд бидний эсрэг” гэсэн томъёоллын хүрээнд үйлчилдэг гэж үзсэн⁶⁰. Иймээс байгаль орчны доройтлын асуудал дээр чухам хэн нь түрэмгийлэл үйлдэж хэн нь дайсан болсон вэ гэдгийг олж тогтоох бэрхшээлтэй юм. Даерын үзэж байгаагаар байгаль орчны хохирол нь өөрөө түрэмгийлэгч эсвэл аюулгүй байдлыг бусниулагч болохгүй, харин хүмүүсийн үйлдлийн үр дүнд байгаль орчны хохирол учирдаг⁶¹. Ингэснээр аюулгүй байдлын хүрээнд уг асуудлыг шийдвэрлэх боломжгүй болдог. Тиймээс тэд цаашид сэрэмжлүүлэхдээ “хэрэв хүмүүсийн эрүүл, аюулгүй байдалд нөлөөлж буй бүх юмыг аюулгүй байдлаар авч үзвэл энэхүү ойлголт нь өөрийн утгаа алдаж, бүхий л “муу” гэсэнтэй утга адил үг болох болно” гэжээ⁶². Энэхүү маргааныг мөн л хүний аюулгүй байдлын ойлголтын хүрээнд шилжүүлэн авч үзэж болно.

Хүний аюулгүй байдлын ойлголтыг аюулгүй байдлаас гаргах стратеги болгон ашиглахад

⁵¹ Мөн тэнд, түүнчлэн Ken Booth, “Security and Self: Reflections of a Fallen Realist” in Keith Krause and Michael C. Williams (eds.) *Critical Security Studies: Concepts and Cases* (UK: UCL Press, 1997): 110-р тал.

⁵² Booth, “Security and Emancipation”, 319-р тал.

⁵³ See, Matt McDonald, “Human Security and the Construction of Security”, *Global Society* 16, no. 3 (2002): 278-р тал, Astri Suhrke, “Human Security and the Interests of States”, *Security Dialogue* 30, no. 3 (1999): 269-р тал болон T.R., Annick Wibben, “Human Security Toward an Opening”. *Security Dialogue* 39, no.4 (2008).

⁵⁴ UNDP, *Human Development Report 1994*, Chapter 2: ‘New Dimensions of Human Security’, 23, http://hdr.undp.org/reports/global/1994/en/pdf/hdr_1994_ch2.pdf.

⁵⁵ Мөн тэнд.

⁵⁶ See, for instance, Roland Paris, “Human Security: Paradigm Shift of Hot Air?”, *International Security* 26, no. 2 (Fall 2001): 88, and Suhrke, 269-р тал.

⁵⁷ Paris, 88-р тал.

⁵⁸ Daniel Deudney, “The Case against Linking Environmental Degradation and National Security”. *Millennium* 19, no. 3 (1990): 441-450.

⁵⁹ Deudney, 462-р тал.

⁶⁰ Мөн тэнд. 467-р тал.

⁶¹ Duyer, 441-450-р тал.

⁶² Deudney, 464-р тал.

бэрхшээлтэй хоёрдугаар асуудал нь хувь хүмүүсийг аюулгүй байдлын объект болгож байгаа асуудал юм. КСАБО-ыг боловсруулагчдын үзэж байгаагаар аюулгүй байдлыг дандаа ямар нэгэн бүлэг хүмүүсийн нэрийн өмнөөс авч хэрэгжүүлдэг. Тиймээс аюулгүй байдалд хувь хүнийг авч үздэг минималист хандлага нь аюулгүй байдлын үйл ажиллагааны талбарыг хангалттай хамарч чадахгүй. Уламжлалт ёсоор анархи буюу хэв журамгүй байдлаас гарахын тулд хувь хүмүүс улсын бүрэн эрхэд өөрсдөө аюулгүй байдлаас хангах эрхийг шилжүүлсэн⁶³. Ингэснээр хувь хүний бүхий л хэрэгцээ, шаардлагыг хамарсан аюулгүй байдал нь олон улсын харилцааны талбарт утгаа алдах юм⁶⁴. Гэсэн хэдий ч энэ нь тухайн улсын тодорхой нэг аюулгүй байдлын үйл ажиллагааг засан залруулах боломжгүй гэсэн үг биш юм. Гагцхүү аюулгүй байдлын салбарт өөрчлөлт оруулахын тулд аюулгүй байдлын үндсэн ойлголт, үйл ажиллагааны утгыг алдагдуулахгүйгээр авч үзэх нь зүйтэй юм.

Тиймээс нийгмийн асуудлыг аюулгүй байдлын асуудлаас гаргах стратегийг боловсруулахын тулд энэхүү судалгаагаар хүний аюулгүй байдлын ойлголтыг улсын аюулгүй байдлын гол хэрэглэгдэхүүн болгохыг санал болгож байна. Ингэснээр улсаас тусламж хүссэн хүмүүсийг (орогнол хүсэгчид г.м.) аюулгүй байдлын асуудал гэж авч үзэхгүйгээр харин хүмүүнлэгийн үүрэг болгон авч үзэх боломжтой юм.

Хүний аюулгүй байдлын ойлголтын үндэс нь болсон ёс суртахууны үзэл суртал нь аюулгүй байдлын асуудлаас гаргах нилээн хүчтэй стратеги болгож байна. Энэ нь ердийн хүмүүсийг онцгойлон авч үзэж, “хүний амьдрал болон итгэл үнэмшлийг” хамгаалдаг⁶⁵. Хүний аюулгүй байдлын философ үзэл суртал нь хүмүүсийн амийг аварч, зөрчилдөөний үеэр хувь хүмүүсийн шаналалыг багасгахад чиглэсэн хүмүүнлэгийн байгууллагуудын үйл ажиллагаанаас үүсэлтэй юм⁶⁶. Ийнхүү хүний аюулгүй байдлын ойлголтыг нийгмийн асуудлыг аюулгүй байдлаас гаргах стратеги болгож авч үзэхийн тулд тухайн улс орны хүмүүнлэгийн үүргийг онцлон тэмдэглэж, энэ нь хэрхэн хүний эрхийг хүндэтгэх, хүмүүсийн гарал үүсэл, үндэс угсаа, шашин шүтлэгээр ялгаварлахгүйгээр тэгш эрхийн зарчмуудыг хэрэгжүүлэгч гэдгийг харуулснаар боловсруулж болно. Ингэснээр нийгмийн асуудлыг аюулгүй байдлын асуудлаас гаргаж, аюулгүй байдлыг багасгах бус нэмэгдүүлэх боломжийг олгож болох юм.

Дүгнэлт болон цаашид хийх судалгаа

Энэхүү өгүүлэлд Копенгаген сургуулийн аюулгүй байдлын онолын (КСАБО) үндсэн ойлголтуудыг тайлбарлаж, тус онолын дэвшилтэт тал болсон аюулгүй байдлын асуудалд дэвшүүлэх, аюулгүй байдлын асуудлаас гаргах зэрэг шинэлэг асуудлуудыг танилцууллаа. Мөн тус онолд үгүйлэгдэж байсан “desecuritization” буюу “аюулгүй байдлын асуудлаас гаргах” стратегийг гүйцэд боловсруулах үүднээс хүний аюулгүй байдлын ойлголтыг хэрхэн хэрэглэж болох талаар саналаа дэвшүүллээ. Ингэснээр хүний аюулгүй байдлын ойлголтыг аюулгүй байдлын асуудалд хэрэглэснээр улсын хүмүүнлэг чиг үүргийг чухалчилж, хүний эрхийг хүндэтгэн хамгаалах үндэс суурийг дэлгэрүүлснээр тухайн улс нь орогнол хүсэгчид гэх мэт хүмүүсийг аюулгүй байдлын асуудал бус харин хүмүүнлэгийн үүрэг хэмээн хүлээн авч үзэх бололцоотойг харуулсан. Аюулгүй байдлын асуудлыг улс-төвтэй бус хүн-төвтэй болгосон тохиолдолд нийгмийн асуудлыг заавал аюулгүй байдлын асуудалд дэвшүүлж, улмаар онцгой арга хэмжээг авахгүйгээр тайван замаар шийдвэрлэж болох юм. Тиймээс цаашид КСАБО-ын боловсруулсан аюулгүй байдлын асуудалд дэвшүүлэх, аюулгүй байдлын асуудлаас гаргах зэрэг нэр томъёог ашиглан хүн амын шилжилт хөдөлгөөн зэрэг олон улсын харилцааны салбарт шинээр гарч ирж буй асуудлыг судалж болох юм.

⁶³ Barry Buzan, *People, States and Fear: An Agenda for International Security Studies in the post-Cold War Era* (Hertfordshire: Harvester Wheatsheaf, 1991): 39-р тал.

⁶⁴ Weaver, ‘Securitization and Desecuritization’, 48-р тал.

⁶⁵ UNDP, *Human Development Report 1994*, 22-р тал.

⁶⁶ Suhrke, 269-р тал.

Ашигласан ном хэвлэл, өгүүлүүд:

1. Adler, Emanuel. "Seizing the Middle Ground: Constructivism in World Politics". *European Journal of International Relations* 3, no. 3 (1997): 319-363.
2. Arfi, Badredine. "Ethnic Fear: The Social Construction of Insecurity". *Security Studies* 8, no. 1 (1998): 151-203.
3. Ashley, Richard K. "Untying the Sovereign State: A Double Reading of the Anarchy Problematique". *Millennium: Journal of International Studies* 17, no. 2 (1988): 227-262.
4. Balzacq, Thierry. "The Three Faces of Securitization: Political Agency, Audience and Context". *European Journal of International Relations* 11, no.2 (2005): 171-201.
5. Booth, Ken. "Security and Emancipation". *Review of International Studies*, no 17 (1991): 313-326.
6. Booth, Ken and Smith, Steve (eds.) *International Relations Theory Today*. Cambridge: Polity Press, 1995.
7. Booth, Ken. "Security and Self: Reflections of a Fallen Realist" in Krause, Keith and Williams, Michael C. (eds.) *Critical Security Studies: Concepts and Cases*. UK: UCL Press, 1997.
8. Buzan, Barry. *People, States and Fear: An Agenda for International Security Studies in the post-Cold War Era*. Hertfordshire: Harvester Wheatsheaf, 1991.
9. Buzan, Barry. "New Patterns of Global Security in the Twenty-first Century". *International Affairs* 67, no. 1 (1991): 431-451.
10. Buzan, Barry. "Rethinking after the Cold War". *Cooperation and Conflict* 32, no. 1 (1997): 5-28.
11. Buzan, Barry, Waever, Ole and de Wilde, Jaap. *Security: A New Framework for Analysis*. Boulder: Lynne Rienner, 1998.
12. Campbell, David. *Writing Security: United States Foreign Policy and the Politics of Identity*. Manchester: Manchester University Press, 1992.
13. Deudney, Daniel. "The Case Against Linking Environmental Degradation and National Security". *Millennium* 19, no. 3 (1990): 461-476.
14. Dyer, Hugh C. "Environmental Security and International Relations: The Case for Enclosure".
15. Eriksson, Johan. Book Review: 'Security: A New Framework for Analysis', *Journal of Contingencies and Crisis Management* 9, no. 1 (March 2001): 61-63.
16. Haftendorn, Helga. "The Security Puzzle: Theory-Building and Discipline-Building in International Security". *International Studies Quarterly* 35 (1991): 3-17.
17. Hansen, Birthe (ed.) *European Security 2000*. Copenhagen: Political Studies Press, 1995.
18. Herd, Graeme P. and Lofgren, Joan. "Societal Security', the Baltic States and EU Integration". *Cooperation and Conflict* 36, no.3 (2001): 273-296.
19. Hopf, Ted. "The Promise of Constructivism in International Theory". *International Security* 23, no.1 (1998): 171-200.
20. Huysmans, Jef. 'Migrants as a Security Problem: Dangers of 'Securitizing' Societal Issues' in Miles, Robert and Thranhardt, Dietrich. *Migration and European Integration*. London: Pinter Publishers, 1995.
21. Huysmans, Jef. "Revisiting Copenhagen: Or, On the Creative Development of a Security Studies Agenda in Europe". Review Article: *European Journal of International Relations* 4, no. 4 (1998): 479-505.
22. Huysmans, Jef. "The Question of the Limit: Desecuritization and the Aesthetics of Horror in Political Realism". *Millennium: Journal of International Studies* 27, no.3: 569-589.
23. Krause, Keith and Williams, Michael C. (eds.) *Critical Security Studies: Concepts and Cases*. UK: UCL Press, 1997.
24. Krause, Keith. "Critical Theory and Security Studies". *Cooperation and Conflict* 33, no. 3 (1998): 298-333.
25. Lipschutz, Ronnie D. (ed.) *On Security*. New York: Columbia University Press, 1995.
26. Mathews, Jessica Tuchman. "Redefining Security". *Foreign Affairs* 68, no. 2 (1989): 162-177.
27. MacDonald, Matt. "Human Security and the Construction of Security". *Global Society* 16, no. 3 (2002): 277-295.
28. MacDonald, Matt. "Securitization and the Construction of Security". *European Journal of International Relations* 14, no.4 (2008): 563-587.
29. Miles, Robert and Thranhardt, Dietrich. *Migration and European Integration*. London: Pinter Publishers, 1995.
30. Nye, Joseph and Lynn-Jones, Sean M. "International Security Studies". *International Security* 12, no.4 (1988): 5-27.
31. Paris, Roland. "Human Security: Paradigm Shift or Hot Air?". *International Security* 26, no. 2 (Fall 2001): 87-102.
32. Roe, Paul. "Misperception and Ethnic Conflict: Transylvania's Societal Security Dilemma". *Review of International Studies*, no 28 (2002): 57-74.
33. Stritzel, Holger. "Towards a Theory of Securitization: Copenhagen and Beyond". *European Journal of International Relations* 13, no.3 (2007): 357-383.
34. Suhrke, Astri. "Human Security and the Interests of States". *Security Dialogue* 30, no. 3 (1999): 265-276.
35. Ullman, Richard. "Redefining Security", *International Security* 8, no.1 (1983): 129-153.

36. UNDP, *Human Development Report 1994, Chapter 2: 'New Dimensions of Human Security'*, 23. Available at http://hdr.undp.org/reports/global/1994/en/pdf/hdr_1994_ch2.pdf.
37. Walt, Stephen M. "The Renaissance of Security Studies". *International Studies Quarterly* 35 (1991): 211-239.
38. Waever, Ole. 'What Is Security? - The Securityness of Security' in Hansen, Birthe (ed.) *European Security 2000*. Copenhagen: Political Studies Press, 1995.
39. Waever, Ole. 'Securitization and Desecuritization' in Lipschutz, Ronnie D. (ed.) *On Security*. New York: Columbia University Press, 1995.
40. Wendt, Alexander. "Anarchy is What States Make of it: Social Construction of Power Politics", *International Organization* 46, no. 2 (1992): 391-425.
41. Wibben T.R., Annick. "Human Security Toward an Opening". *Security Dialogue* 39, no.4 (2008): 455-462.
42. Williams, Michael C. "Words, Images, Enemies: Securitization and International Politics", *International Studies Quarterly* 47 (2003): 511-531.
43. Wolfers, Arnold. *Discord and Collaboration*. Baltimore: Johns Hopkins University Press, 1962.
44. Zalewski, Marysia and Encloe, Cynthia. 'Questions about Identity in International Relations' in Booth, Ken and Smith, Steve (eds.) *International Relations Theory Today*. Cambridge: Polity Press, 1995.